



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 2111

Баян-Адарга сум

Г.Алтансүвдэд нэг удаагийн
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 60.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн нярав Г.Алтансүвдэд нэг удаагийн буцалтгүй тусламж болох 22,284,800 (Хорин хоёр сая хоёр зуун наян дөрвөн мянга найман зуу) төгрөгийг олгосугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэгийн зардлын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Агиймаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

С.БАТ-ЭРДЭНЭ